



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 186

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хэнтий аймаг дахь Политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 5,220,200.00 /таван сая хоёр зуун хорин мянга хоёр зуун/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг хичээл сургалтад ашиглах зориулалтаар акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Хэнтий аймаг дахь Политехник коллежийн захирал Г.Нямхатан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, хичээл сургалтад ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталж, данснаас хасаж сэлбэгээр худалдсан тракторын улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг, дээрх арга хэмжээний биелэлтийн хамт 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



000040

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн
186... дугаар тогтоолыг хавсралт



Хэнтий аймаг дахь Политехник коллежийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас
хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Бага оворын трактор, 60-12 ХЭ, арал№G207132010900 6	2006/ 2006	2,390,200.00	2,390,200.00
2	Бага оворын трактор, 60-13 ХЭ, арал№10605060167	2008/ 2008	2,400,000.00	2,400,000.00
3	Цахилгаан суурин хөрөө, харуул	2011/ 2011	430,000.00	430,000.00
	Нийт дүн		5,220,200.00 /таван сая хоёр зуун хорин мянга хоёр зуун/	5,220,200.00 /таван сая хоёр зуун хорин мянга хоёр зуун/